



ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2023.06.30

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

ЗТХЯ-ны харьяа байгууллага болох Далайн захиргааны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

Далайн захиргааны 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалын хэрэгжилт, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ хяналт тавьж хэрэгжилтийг гаргах шаардлага бүхий 5 үзүүлэлтээр 192 арга хэмжээг дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **82.4** хувьтай байна.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. Далайн захиргааны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 76 арга хэмжээ тусгагдан эхний хагас жилд **82.9** хувийн хэрэгжилттэй байгаа бөгөөд хэрэгжилтийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс (хувиар)						Хугацаа болоогүй	Хэрэгжилт (хувиар)
	100	90	70	50	30	0		
76	45	5	7	3	10	1	5	82.9

Далайн захиргаа нь 2023 оны онд нийт 76 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн үнэлгээтэй 45, 90 хувийн үнэлгээтэй 5, 70 хувийн үнэлгээтэй 7, 50 хувийн үнэлгээтэй 3, 30 хувийн үнэлгээтэй 10, хэрэгжээгүй 1, хугацаа болоогүй 5 арга хэмжээ байгаа бөгөөд хэрэгжилт дунджаар **82.9** хувьтай үнэлэгдсэн байна.

“Хэрэгжээгүй” буюу 0 үнэлгээтэй 1 арга хэмжээ:

1. Арга хэмжээ: 2.3.5. Хийлдэг аврах завины стандарт (Inflatable life rafts)-ын төслийг боловсруулах.

Зорилтот түвшин: 1-2-р улиралд: Стандартын төслийг Үндэсний стандарт боловсруулах, MNS стандартад нийцүүлэн боловсруулна.

Хэрэгжилт: Аврах завины ISO9650 олон улсын багц стандартыг худалдан авах хүсэлтээ 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01/72 тоот албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсэн.

Олон улсын стандартчилал, хэмжил зүйн байгууллагаас уг багц стандартыг шинэчлэн батлах ажил хийгдэж байгаагаас шалтгаалан худалдан авах ажил түр хойшлогдсон.

Хийлдэг аврах завины ISO9650 олон улсын багц стандартыг Үндэсний стандарт боловсруулах MNS стандартад нийцүүлэн боловсруулах ажил хийгдэж байна.

“Хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувийн үнэлгээтэй 10 арга хэмжээ:

I. Арга хэмжээ: 1.1.1. Архангай аймгийн Өгийнуур суманд усан замын тээврийн “Хяналтын пост”-ыг өөрийн эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар байгуулах

Зорилтот түвшин: 2-р улиралд: Барилгын ажлыг эхлүүлнэ

Хэрэгжилт: Архангай аймгийн Өгийнуур суманд усан замын тээврийн “Хяналтын пост” байгуулах ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хуудаст болон өдөр тутмын сонинд зарласан. Тендерийг 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр нээлтийг хийхэд аж ахуй нэгжүүдээс үнийн санал ирээгүй учир худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тендерийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтийг хэлэлцэн дахин зарлахаар төлөвлөн ажиллаж байна.

II. Арга хэмжээ: 1.1.2. Хөвсгөл нуурын эрэгт байрлах усан замын хяналт, зохицуулалтын байрны дэргэд хяналтын тусгай зориулалтын 3-4 завь зогсох боломжтой зогсоол барих

Зорилтот түвшин: 2-р улиралд: Барилгын ажлыг эхлүүлнэ.

Хэрэгжилт: Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь усан замын тээврийн “Хяналтын пост”-ын дэргэд хяналтын зориулалттай завинуудыг зогсох боломжтой зогсоол байгуулах ажил гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хуудаст болон өдөр тутмын сонинд зарласан. Тендерийг 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр нээлтийг хийхэд аж ахуй нэгжүүдээс үнийн санал ирээгүй учир худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тендерийн баримт бичгийн шалгуур үзүүлэлтийг хэлэлцэн дахин зарлахаар төлөвлөн ажиллаж байна.

III. Арга хэмжээ: 2.3.4. Усан замын тээврийн хэрэгслийг барих (угсрах) талаарх Канадын Construction Standards for Small Vessels (2010) – TP 1332 E стандартын орчуулгыг 2022 онд СХЗГ-аас шинэчлэн баталсан Үндэсний стандарт боловсруулах MNS стандартад нийцүүлэн боловсруулах

Зорилтот түвшин: 1-2-р улиралд: Стандартын төслийг Үндэсний стандарт боловсруулах MNS стандартад нийцүүлэн боловсруулна.

Хэрэгжилт: Стандартын төслийг 2022 онд Стандарт, хэмжил зүйн газраас шинэчлэн баталсан Үндэсний стандарт боловсруулах MNS стандартад нийцүүлэн боловсруулах ажил хийгдэж байна.

IV. Арга хэмжээ: 2.3.6. Усан замын зорчигч тээвэрлэлтийн аюулгүй байдлыг сайжруулах талаар БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуурын технологийн институт (KIMFT) болон БНСУ-ын Далайн тээврийн аюулгүй байдлын захиргаа (KOMSA)-тай хамтран ажиллах

Зорилтот түвшин: 2-р улиралд: Усан замын тээврийн салбарын эрх зүйн баримт бичгүүдийг орчуулах ажлыг хийж дуусгана.

Хэрэгжилт: БНСУ-ын Далайн шинжлэх ухаан, технологийн хүрээлэн (KIOST)-тэй хамтран “Монгол Улсын Хөвсгөл нууран дээр усан замын тээврийн судалгаа, эко усан зогсоол байгуулах ТЭЗҮ боловсруулж, судалгааны усан онгоц нэвтрүүлэх төсөл”, мөн БНСУ-ын Далайн тээврийн аюулгүй байдлын захиргаа (KOMSA)-тай хамтран “Монгол Улсын далайн тээврийн салбарын хүний нөөцийг бэлтгэх, дотоодын усан замын тээврийн хяналт, аюулгүй байдлыг сайжруулах” төслүүдийг хамтран хэрэгжүүлэхээр тохиролцсоны дагуу төслийн баримт бичгүүдийг боловсруулсан.

Төслүүдийн баримт бичгүүдийг Монгол Улсын Сангийн ямаар дамжуулан БНСУ-ын Сангийн яаманд хүргүүлэх зорилгоор 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 1/24 тоот албан бичгээр ЗТХ-ийн сайдад хүргүүлсэн.

Улмаар Сангийн ямаар дамжин БНСУ-ын Элчин сайдын яаманд уламжлагдсанаар БНСУ-ын Сангийн яаманд хүргэгдээд байна.

- Усан замын тээврийн салбарын эрх зүйн баримт бичгүүдийг орчуулан, дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд орчуулгын ажил хийгдэж байна.

V. Арга хэмжээ: 2.3.9. Усан замын тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх

Зорилтот түвшин: 1-р улиралд: Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын төлөвлөгөө, удирдамжийг батална. 3-р улиралд: Батлагдсан удирдамжийн дагуу зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.

Хэрэгжилт: Усан замын тээврийн хяналтын улсын байцаагчдын эрхийг сунгах, шинээр авах хүсэлтийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 1/25 тоот албан бичгээр ЗТХЯ-ны Салбарын хяналтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлсэн.

Мөн усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг улсын ахлах байцаагчтай хамтран боловсруулсан бөгөөд №4.4.1 дугаартай “Усан замын тээврийн аюулгүй байдлыг шалгах” хяналтын хуудсыг шинэчлэн батлуулахаар 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр ЗТХЯ-ны Салбарын хяналтын газарт хүргүүлсэн.

Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын удирдамжийг батлуулахаар ЗТХЯ-ны Салбарын хяналтын газартай хамтран ажиллаж байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны Салбарын хяналтын газар болон Далайн захиргаа хооронд Урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай удирдамжийг 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан. Тус удирдамжийн дагуу Архангай, Хөвсгөл, Увс, Баян-Өлгий аймгуудад 2023 оны 06 дугаар сарын 14-27-ны өдрүүдэд ажиллаж байна.

ЗТХЯ-ны Салбарын хяналтын газар, Хөвсгөл, Увс, Баян-Өлгий аймгуудын авто тээвэр, усан замын хяналтын улсын (ахлах) байцаагч, Далайн захиргаа Усан замын тээврийн бүртгэл, хяналтын албаны мэргэжилтэн, улсын байцаагч нар хамтран 2023 оны 06 дугаар сарын 17-23-ны өдрүүдэд Хөвсгөл, Увс, Баян-Өлгий аймгуудад хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад нийт 12 иргэн, аж ахуйг нэгжийг хамруулав. Илрүүлсэн зөрчлийг арилгуулахаар иргэдэд улсын (ахлах) байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлээд байна.

VI. Арга хэмжээ: 2.4.1. Олон улсын далайн байгууллага болон бусад олон улсын байгууллагын олон улсын гэрээ, конвенц, бусад холбогдох баримт бичиг болон тэдгээрийн нэмэлт өөрчлөлтөд Монгол Улс нэгдэн орох эсэх талаар санал боловсруулан холбогдох мэдээлэл бэлтгэх

Зорилтот түвшин: 2-р улиралд: Олон улсын гэрээ, конвенц, болон тэдгээрийн нэмэлт өөрчлөлтөд нэгдэн орох эсэх талаар судална.

Хэрэгжилт: “Далайг хог хаягдал болон бусад зүйлсээр бохирдуулахаас урьдчилан сэргийлэх тухай” 1975 оны конвенц болон “Далайн тээврийн хөдөлгөөнийг хөнгөвчлөх тухай” 1965 оны конвенцод тус тус нэгдэн орох талаар судалгаа хийгдэж байна мөн конвенцуудын хамгийн сүүлийн нэмэлт өөрчлөлтүүдийг багтаасан хувилбаруудыг монгол хэлнээ хөрвүүлэх ажил хийгдэж байна.

VII. Арга хэмжээ: 2.6.1. Гадаадын их, дээд сургууль, сургалтын төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, боловсон хүчнийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллах

Зорилтот түвшин: 2-4-р улиралд: Салбарын их, дээд сургууль, сургалтын төвүүдэд боловсон хүчнийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллана.

Хэрэгжилт: Далайн захиргааны ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх 2023 оны сургалтын хөтөлбөр-ийг 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр 06 дугаар тушаалаар батлуулан ажиллаж байна.

VIII. Арга хэмжээ: 2.6.2. “Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах

Зорилтот түвшин: 2-р улиралд: Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний ажилтны сургалтад холбогдох мэргэжилтнүүдийг хамруулна.

Хэрэгжилт: Журмын дагуу мэргэжлийн зөвлөлд салбарын мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулах зорилгоор “Монголын завьчдын нэгдсэн холбоо” НҮТББ, “Монголын усчин-аврагчдын холбоо” НҮТББ, “Монголын рафтингийн холбоо” НҮТББ болон “Усан замчны толь бичиг” НҮТББ руу холбогдох албан тоотыг хүргүүлж, санал авсан.

Ирүүлсэн саналыг үндэслэн дээрх төрийн бус байгууллагууд болон Далайн захиргааны холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлийг Далайн захиргааны даргын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/17 дугаар тушаалаар байгуулаад байна.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийг үндэслэн Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/97, А/231 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам” хүчингүй болсон.

Тус асуудлаар Зам, тээврийн хөгжлийн яамнаас Боловсрол, шинжлэх ухааны яаманд асуудал шийдвэрлэх тухай албан тоот бичгийг хүргэгдсэн.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас тус асуудлыг шийдвэрлэх чиглэл өгсний дараа мэргэжлийн шалгалт авах ажлыг зохион байгуулна.

Далайн захиргаанаас “Усан замчны толь бичиг холбоо” ТББ-ын сургалтад бүрэн хамрагдсан иргэдээс 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр шалгалт авахаар төлөвлөөд байгаа бөгөөд энэ талаар мэдэгдлийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/226 тоот албан бичгээр тус төрийн бус байгууллагад хүргүүлээд байна.

IX. Арга хэмжээ: 3.3.1. Олон улсын далайн байгууллагын Ерөнхий Ассамблейн хурал болон бусад салбар хороодын холбогдох хурал зөвлөгөөнд идэвхтэй оролцож гишүүн орны хувьд ОУДБ-тай хамтын ажиллагааг өргөжүүлж ажиллана.

Зорилтот түвшин: 1-4-р улиралд: Оролцох шаардлагатай хурал зөвлөгөөнүүдийн судалгааг гаргаж. ОУДБ-тай хамтын ажиллагааг өрнүүлж ажиллана.

Хэрэгжилт: ОУДБ-ын Олон улсын хөдөлгөөнт хиймэл дагуулын байгууллагын хурал 2023 оны 10 дугаар сарын 09-нөөс 13-ны өдрүүдэд зохион байгуулагдах тов гарсан.

Мөн, ОУДБ-ын Ерөнхий Ассамблейн 33 дугаар чуулган 2023 оны 11 дүгээр сарын 27-ноос 12 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулагдах тов гарсан. Чуулганы үеэр ОУДБ-ын зөвлөлийн гишүүн орнуудыг А, В, С ангилалд сонгох сонгуультай холбогдуулан Лондон дахь Монгол Улсын Элчин сайдын яамны зүгээс нэр дэвшигч орнуудын сонгуульт ажилд Монгол Улсаас дэмжлэг үзүүлэх тухай хүсэлт бүхий ноот бичгүүдийг Далайн захиргаанд ирүүлж байгаа бөгөөд хүсэлтүүдийг судлан үзэж, сонгуульд дэмжсэний хариуд сөргүүлэн тавих хамтын ажиллагааны саналыг боловсруулж байна.

X. Арга хэмжээ: 3.4.6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, худалдан авах ажиллагааг ЗТХЯ-нд тайлагнаж ажиллах

Зорилтот түвшин: 1-4-р улирал: Тухайн онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааг улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар ЗТХЯ-нд тайлагнана.

Хэрэгжилт: ЗТХЯ-ийн сайдын 2023 оны А/18 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар Далайн захиргааны 2023 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажлын жагсаалтыг баталсны дагуу Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг www.tender.gov.mn хуудааст оруулж, батлуулсан.

Тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хороог Далайн захиргааны даргын тушаалаар байгуулж, тендерийн баримт бичгийг боловсруулах ажлын хүрээнд барилгын ажлын даалгаврыг боловсруулж, төрийн худалдан авах ажиллагааны цахим системд зарласан. Бүтээн

байгуулалтын ажлуудын тендерийг амжилттай зохион байгуулсан ба барилгын угсралтын ажлууд эхлээд байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын нэр: Тусгай зориулалтын завины зогсоол байгуулах (Хөвсгөл, Хатгал)- Санал ирүүлсэн оролцогч байгаагүй тул дахин зарлахаар ажиллаж байна.

Тендер шалгаруулалтын дугаар: МУДЗ/202302003

2. Тендер шалгаруулалтын нэр: Суурин компьютер нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: МУДЗ/202302005

- гэрээ байгуулахаар болсон

3.Тендер шалгаруулалтын нэр: Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоол байгуулах (Орон нутагт)

Тендер шалгаруулалтын дугаар: МУДЗ/202302002

- гэрээ байгуулахаар болсон

4.Тендер шалгаруулалтын нэр: Өргөгч кран

Тендер шалгаруулалтын дугаар: МУДЗ/202302006-гэрээ байгуулсан.

5.Тендер шалгаруулалтын нэр: Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоол (Улаанбаатар 1, орон нутаг 1) барих ажил

Тендер шалгаруулалтын дугаар: МУДЗ/202302002 - гэрээ байгуулахаар болсон (Ховд)

6.Тендер шалгаруулалтын нэр: Хяналтын пост (Архангай, Өгийнуур)

Тендер шалгаруулалтын дугаар: МУДЗ/202302001- дахин зарлахаар ажлын даалгаварт өөрчлөлт оруулж байна.

Эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувийн хэрэгжилттэй байгаа 3 арга хэмжээ:

I. Арга хэмжээ: 1.1.5. Эрэлт хэрэгцээг нь харгалзан Монгол орны томоохон гол, мөрний эрэг дагуу жижиг, бага оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоол байгуулах

Зорилтот түвшин: 2-р улиралд: Барилгын ажлыг эхлүүлнэ.

Хэрэгжилт: Орон нутгийн эрэлт хэрэгцээ, хүсэлтийг үндэслэн жижиг, бага оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоолыг Нийслэлд Туул голын эрэгт, Ховд аймгийн Буянт голын эрэгт тус тус барихаар төлөвлөсөн. Энэхүү ажил гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах багц тендерийг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны газрын www.tender.gov.mn цахим хуудас болон өдөр тутмын сонинд зарласан. Тендерийг 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр нээхэд багц 2 “Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоол (Улаанбаатар) барих ажил”-д ямар нэгэн хуулийн этгээд санал ирүүлээгүйгээс амжилтгүй болсон. Багц 1-ийн сонгон шалгаруулалтыг 2023 оны 06 дугаар сарын 08-ны өдөр дахин зарласан. Харин Багц 1 “Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоол (Ховд аймагт) барих ажил”-д “Ховд шинэ асар” ХХК гэсэн хуулийн этгээд үнийн санал ирүүлсэн. Энэхүү тендерийг шаардлага хангасан гэж үнэлэгдсэн бөгөөд тус компанид гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр албан бичгээр хүргүүлсэн ба 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр гэрээ байгуулсан. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавин хугацаанд нь ажлыг хүлээн авахаар ажиллаж байна.

II. Арга хэмжээ: 1.1.6. Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь усан замын тээврийн “Хяналтын пост”-ын завины өвлийн битүү зогсоолын барилгад өргөгч цамхаг (кран) суурилуулах

Зорилтот түвшин: Ажлын гүйцэтгэлийг хүлээн авч, гэрээг дүгнэнэ.

Хэрэгжилт: Далайн захиргааны даргын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/32 дугаар тушаалаар байгуулсан Үнэлгээний хороо нь тендерийн МУДЗ/202302006 дугаартай “Өргөгч кран (Хөвсгөл, Хатгал) нийлүүлэх ажил”-ын тендер сонгон шалгаруулалтыг 2023 оны 04 дүгээр сарын 17-ноос 05 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулсан. Уг сонгон шалгаруулалтад “Түмэнтөмөрт” ХХК шалгарсан бөгөөд тус компанитай 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдөр гэрээ байгуулсан ба гэрээний хэрэгжилтэд хяналт тавин хугацаанд нь барааг хүлээн авахаар ажиллаж байна.

III. Арга хэмжээ: 2.2.1. Далбааны эзэн улсын хяналтын улсын байцаагчийн эрх авах асуудлыг шийдвэрлүүлэх

Зорилтот түвшин: 2-р улиралд: Далбааны эзэн улсын хяналтын 4-өөс доошгүй улсын байцаагчийн эрх авна.

Хэрэгжилт: Далбааны эзэн улсын хяналтын улсын 4 байцаагчдын эрх авах хүсэлтийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 1/25 тоот албан бичгээр, 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01/118 тоот албан бичгээр ЗТХЯ-ны Салбарын хяналтын газарт хүргүүлсэн.

Үүний дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар Хөлөг онгоц бүртгэл, хяналтын албаны ахлах мэргэжилтэн Б.Оргил, Далбааны эзэн улсын хянан шалгагч Г.Золбоо нарт Далбааны эзэн улсын хяналтын улсын байцаагчийн эрх олгоод байна.

2.2 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Эрхзүйн актын нэр	Нийт арга хэмжээ	Хэрэгжилт (хувиар)	Үүнээс хэрэгжилтийн хувиар					
			100	70	30	0	Хугацаа болоогүй	Хяналтаас хассан
Монгол Улсын хууль	6	100.0	6	-	-	-	-	-
Ерөнхийлөгчийн зарлиг	3	70.0	-	2	-	-	1	-
Дүн	9	92.5	6	2	-	-	1	-

2.3 Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалын хэрэгжилт:

Нийт заалт	Үүнээс (хувиар)						Хэрэгжилт хувь
	100	70	30	0	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
24	14	10	-	-	-	-	87.5

1.4. Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:

№	Мэдээллийн агуулга	Байршуулбал зохих мэдээллийн төрөл	Байршуулсан мэдээллийн төрөл	Тайлант хугацаанд байршуулсан (хувиар)	Хугацаа хоцроож байршуулсан (хувиар)					Хугацаа болоогүй (төрийн тоо)	Хэрэгжилт (хувиар)
					100	90	70	50	30		
1	Төсөв, гүйцэтгэл	14	7	5	-	-	-	1	1	7	75.7
2	Хөрөнгө оруулалт, тендэр, худалдан авалт	5	4	1	-	-	-	1	2	1	32.5
3	Бусад	8	7	6	1	-	-	-	-	1	98.6
Дүн		27	18	12	1	-	-	2	3	9	75.0

1.5. Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт:

д/д	Шалгуур үзүүлэлтийн төрөл	Хэрэгжүүлэх үзүүлэлтийн тоо	Үүнээс (хувиар)					Хэрэгжилт (хувиар)
			100	70	30	0	Хугацаа болоогүй	
1	8.2. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	25	18	-	-	7	-	72.0
2	8.3. Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	7	5	-	-	2	-	71.4
3	8.4. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	15	14	-	-	1	-	93.3
4	8.5. Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдал	6	6	-	-	-	-	100.0
5	8.6. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	3	2	-	-	1	-	66.7
Дүн		56	45	-	-	11	-	80.4

“Хэрэгжээгүй” буюу 0 үнэлгээтэй 11 арга хэмжээ байна.

- 8.2.1. үйл ажиллагааны стратегийн зорилго
- 8.2.2. үйл ажиллагааны стратегийн зорилт
- 8.2.2. олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг
- 8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт
- 8.2.3. дотоод аудит
- 8.2.7. албан тушаалын тодорхойлолт
- 8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр
- 8.3.4. хүний нөөцийн стратеги
- 8.3.4. түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам
- 8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар
- 8.6.4. мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл

Гурав. Дүгнэлт:

1. Төлөвлөлтийн байдал:

Далайн захиргааны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хэрэгжүүлэх хугацааг яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон бусад төлөвлөгөөтэй уялдуулан улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөн БТГ, ХШҮДАГ-аар гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг хянуулан батлуулсан байна.

Тухайн жилд хийхээр төлөвлөсөн 76 арга хэмжээний 52 буюу нийт ажлын 68.4 хувийг нь жилийн турш, 3 арга хэмжээ буюу 3.0 хувийг нэгдүгээр улиралд, 11 арга хэмжээ буюу 14.5 хувийг эхний хагас жилд, 10 арга хэмжээ буюу 13.1 хувийг гуравдугаар улиралд тус тус хэрэгжүүлээр төлөвлөсөн байна.

2. Хэрэгжилтийн байдал:

1. Далайн захиргааны үйл ажиллагаанд 2023 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийхдээ тус байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 82.9 хувь, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 92.5, Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалын хэрэгжилт 87.5 хувь, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ 75.0 хувь, мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт 80.4 хувиар тус тус үнэлж, 5 үзүүлэлтээр 192 арга хэмжээний нэгдсэн дүнгээр **82.4** хувьтай байна.

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 1.1.1. Архангай аймгийн Өгийнуур суманд усан замын тээврийн “Хяналтын пост”-ыг өөрийн эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар байгуулах, 1.1.2. Хөвсгөл нуурын эрэгт байрлах усан замын хяналт, зохицуулалтын байрны дэргэд хяналтын тусгай зориулалтын 3-4 завь зогсох боломжтой зогсоол барих, 1.1.5. Эрэлт хэрэгцээг нь харгалзан Монгол орны томоохон гол, мөрний эрэг дагуу жижиг, бага оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоол байгуулах, 1.1.6. Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь усан замын тээврийн “Хяналтын пост”-ын завины өвлийн битүү зогсоолын барилгад өргөгч цамхаг (кран) суурилуулах, 2.3.4. Усан замын тээврийн хэрэгслийг барих (угсрах) талаарх Канадын Construction Standards for Small Vessels (2010) – TP 1332 E стандартын орчуулгыг 2022 онд СХЗГ-аас шинэчлэн баталсан Үндэсний стандарт боловсруулах MNS стандартад нийцүүлэн боловсруулах, 2.3.5. Хийлдэг аврах завины стандарт (Inflatable life rafts)-ын төслийг боловсруулах, 2.3.9. Усан замын тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх гэсэн ажлууд хоёр улирал дараалан хэрэгжилт хангалтгүй хэвээр байна.

3. Далайн захиргааны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны эхний хагас жилийн байдлаар 76 арга хэмжээнээс 100 хувийн биелэлттэй 45 арга хэмжээ, 90 хувийн биелэлттэй 5 арга хэмжээ, 70 хувийн биелэлттэй 7 арга хэмжээ, 50 хувийн биелэлттэй 3 арга хэмжээ, 30 хувийн биелэлттэй 10, тасарсан 1, хугацаа болоогүй 5 арга хэмжээ, хэрэгжилт дунджаар **82.9** хувьтай буюу I улирлаас 26.4 хувь өссөн дүнтэй байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилт тус бүрээр авч үзвэл:

№	Зорилтууд	Арга хэмжээний тоо	Хэрэгжилт (хувиар)	Өөрчлөлт I улирал (хувиар)
1	1.1 Усан замын тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг далайн боомтоор дамжуулан тээвэрлэх талаар холбогдох судалгааг хийх	10	76.0	+63.5
2	2.1 Далай ашиглах тухай хуулийг дагалдан гарах журмуудыг батлуулах, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагааг цахимжуулах	9	100.0	+48.7
3	2.2 Далбааны эзэн улсын хяналтын улсын байцаагчийн эрхийг авч, хяналт шалгалт хийх	2	75.0	+75.0
4	2.3 Усан замын тээврийн салбарт олон улсын стандартыг нэвтрүүлж, салбарын гадаад, дотоод харилцааг хөгжүүлэн, техникийн хяналтын үзлэг, тооллогыг зохион байгуулах	10	67.0	+27.0
5	2.4 Олон улсын далайн байгууллага болон бусад олон улсын байгууллагын олон улсын гэрээ, конвенц, бусад холбогдох баримт бичиг болон тэдгээрийн нэмэлт өөрчлөлтөд монгол улс нэгдэн ороход дэмжлэг үзүүлж, олон улсын хөлөг онгоцны мэдээллийн нэгдсэн платформыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх	3	66.7	+36.7
6	2.5 “Монгол-Саммок ложистик” хамтарсан компанийн үйл ажиллагааг идэвхижүүлэх талаар арга хэмжээг авч ажиллах	1	100.0	-
7	2.6 Салбарын хүний нөөцийн бодлого, төсөл,	2	30.0	-60.0

	хөтөлбөр боловсруулах, хүний нөөцийн сургалтыг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих, бодлогын удирдамжаар хангах			
8	2.7 Монгол улсын хөлөг онгоцны бүртгэлийг өргөжүүлж, техникийн үзлэг шалгалт хийх хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулах	3	85.0	-5.0
9	3.1 Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах	13	89.1	+2.7
10	3.2 Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах	5	97.5	+4.2
11	3.3 Салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх	6	81.7	+8.4
12	3.4 Далайн захиргааны 2023 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж	6	84.0	+17.8
13	4.1 Далайн болон усан замын тээврийн салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хандсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн зөвлөгөөгөөр ханган дэмжлэг үзүүлж ажиллах	6	100.0	+50.0

4. Эхний хагас жилд дуусахаар төлөвлөсөн 11 ажлын 7 нь бүрэн хэрэгжсэн, 2 нь 90%-ийн хэрэгжилттэй буюу дуусах шатандаа, 2 арга хэмжээ нь “Хяналтын пост”-ын завины өвлийн битүү зогсоолын барилгад өргөгч цамхаг (кран) суурилуулах ажлын гүйцэтгэл, гэрээг дүгнэх ажил хийгдэж байгаа, 1 нь зорилтот түвшинд заасан 4 байцаагчийн эрх авахаас 2 байцаагчийн эрх хүлээгдэж байна.

5. Далайн захиргааны 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн дараах зөвлөмжүүдийн хэрэгжилт ахисан байна. Үүнд:

- Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлж ажиллахад анхаарах;

- Хариуцан хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан гол ажлаа хүрсэн үр дүн, зорилтот түвшинтэй нь уялдуулж, 2000 тэмдэгтэд багтаан хэт нуршиж ажлын үйл, явц тоочилгүй, огноог тодорхой дурдан тайлагнаж хэвших;

- Холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөхдөө тухайн жилд хүрэх зорилтот түвшнийг оновчтой тодорхойлж,

- Бүрэн хэрэгжсэн ч тогтмол зохион байгуулагддаг арга хэмжээний биелэлтийг улирал бүр шинэчилж, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан хөрөнгө, санхүүжилт шаардагдахгүйгээр хэрэгжүүлэх боломжтой дүрэм, журмын төслүүдийг боловсруулан батлуулах ажлыг эрчимжүүлэх;

- Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд анхаарч, байгууллагын цахим сайтад ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн мэдээллийг байршуулах боломжийг бүрдүүлэн хөгжүүлэлт хийхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

6. Дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй удаашралтай хэвээр байна. Үүнд:

- Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөр, төлөвлөгөө түүний хэрэгжилт, үр дүн, өргөдөл, гомдлын мэдээ, дүрэм, журмын төслийг хавсралтаар гарган ирүүлэх;

- Хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлахдаа албан хэрэг хөтлөлтийн стандартыг баримтлан, огноо, дугаарыг дурдах;

- Шилэн дансанд байршуулдаг мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх ажлыг шуурхай гүйцэтгэж, мэдээллийг тухай тогтоосон цаг хугацаанд оруулж холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

7. Далайн захиргааны үйл ажиллагаанд 2020, 2021, 2022, 2023 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн үнэлгээний дүнг дараах хүснэгтээр харьцуулан харуулав.

№	Хяналтад байх арга хэмжээ	Эхний хагас жил			
		2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	93.5	88.0	81.0	82.9
2	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	100.0	-	-	-
3	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	94.0	75.0	33.3	92.5
4	ЗТХС-ын тушаалын биелэлт	98.6	90.6	93.6	87.5
5	ТНБД-ын тушаалын биелэлт	100.0	-	-	-
6	Сайдын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт	-	40.0	-	-
7	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	100.0	95.0	88.5	75.0
8	Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлт	97.0	88.2	100.0	80.4
Дундаж үнэлгээ		95.4	87.3	88.7	82.4

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Далайн захиргааны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс хоёр улирал дараалан хэрэгжүүлээгүй дараах ажлыг тухайн тухайн арга хэмжээний зорилтот түвшинд хүргэн ажиллах. Үүнд:

-1.1.1. Архангай аймгийн Өгийнуур суманд усан замын тээврийн “Хяналтын пост”-ыг өөрийн эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар байгуулах,

-1.1.2. Хөвсгөл нуурын эрэгт байрлах усан замын хяналт, зохицуулалтын байрны дэргэд хяналтын тусгай зориулалтын 3-4 завь зогсох боломжтой зогсоол барих,

-1.1.5. Эрэлт хэрэгцээг нь харгалзан Монгол орны томоохон гол, мөрний эрэг дагуу жижиг, бага оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоол байгуулах,

-1.1.6. Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь усан замын тээврийн “Хяналтын пост”-ын завины өвлийн битүү зогсоолын барилгад өргөгч цамхаг (кран) суурилуулах,

-2.3.4. Усан замын тээврийн хэрэгслийг барих (угсрах) талаарх Канадын Construction Standards for Small Vessels (2010) – TP 1332 E стандартын орчуулгыг 2022 онд СХЗГ-аас шинэчлэн баталсан Үндэсний стандарт боловсруулах MNS стандартад нийцүүлэн боловсруулах,

-2.3.5. Хийлдэг аврах завины стандарт (Inflatable life rafts)-ын төслийг боловсруулах,

-2.3.9. Усан замын тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх.

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан байцаагчийн эрх авах, стандарт боловсруулах, төслийн баримт бичиг боловсруулах, уулзалт, хурал зөвлөгөөний судалгаа гаргах, олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орох талаар санал боловсруулах зэрэг төсөв санхүү шаардлагагүй ажлыг бүрэн хэрэгжүүлж ажиллах;

3. Холбогдох хөтөлбөр, төлөвлөгөө түүний хэрэгжилт, үр дүн, өргөдөл, гомдлын мэдээ, дүрэм, журмын төслийг хавсралтаар гарган ирүүлэх;



4. Хариуцан хэрэгжүүлж байгаа арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа дэвшүүлсэн зорилтын хүрээнд зохион байгуулсан гол ажлаа хүрсэн үр дүн, зорилтот түвшинтэй нь уялдуулж, 2000 тэмдэгтэд багтаан ажлын үйл, явц тоочилгүй, огноог тодорхой дурдан, зөв бичгийн алдаагүй тайлагнаж хэвших;

5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, байгууллагын цахим сайтад ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн мэдээллийг байршуулан хөгжүүлэлт хийхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ авч, шилэн дансанд байршуулдаг мэдээллийг хугацаанд нь гүйцэтгэж холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

6. Далайн захиргааны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн гүйцэтгэхэд анхаарч, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.

ТАНИЛЦСАН:

САЙД

С.БЯМБАЦОГТ

ДЭД САЙД

Л.ХАЛТАР

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГА

Д.ОТГОНСҮРЭН

ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН БОДЛОГО
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ИТГЭЛТ

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

А.МӨНХБАТ

БОЛОВСРУУЛСАН:

ХШУДАГ-ЫН ШИНЖЭЭЧ

Л.ШИНЭЧИМЭГ



ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2023 ОНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

(эхний хагас жилийн байдлаар)

№	Хяналтанд байх арга хэмжээ	2023 онд төлөвлөсөн нийт арга хэмжээ	Тухайн улиралд төлөвлөсөн арга хэмжээ (Өссөн дүнгээр)	Хэрэгжилт (хувиар)							
				Дундаж хувь	100	90	70	50	30	0	Хугацаа болоогүй
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	76	71	82.9	45	5	7	3	10	1	5
2	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	9	8	92.5	6	-	2	-	-	-	1
3	Сайдын тушаалын хэрэгжилт	24	24	87.5	14	-	10	-	-	-	-
4	Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ	27	18	75.0	12	1	-	-	2	3	9
5	Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээ	56	56	80.4	45	-	-	-	-	11	-
Нийт		192	177	82.4	122	6	19	3	12	15	15

